



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

15170 Улванбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017. 02. 16. № 02-01/III.
танай _____ -ны № _____ -т

ДАРГА **БАТЛАВ** Л.ЭРДЭНЭЧУЛУУН



Нүүрс ашиглах тусгай зөвшөөрөл
эзэмшигчдийн үйл ажиллагаанд
хяналт шалгалт хийх тухай

Нэг. Зорилго, үндэслэл

Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Нийслэлийн нутаг дэвсгэр дэх нүүрс олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Агаарын тухай, Барилгын тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай, Нийгмийн даатгалын тухай, Хог хаягдлын тухай, Тамхины хяналтын тухай, хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, уул уурхайн олборлолтын дараах техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн түвшинг 5 пунктээр нэмэгдүүлэх нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт хангуулах, далд уурхайн үйл ажиллагааны аюулгүй байдал хангагдан эрсдлийн түвшин бууруулахад шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

Төлөвлөгөөт шалгалтыг дараах чиглэлүүдийн хүрээнд хийж гүйцэтгэнэ. Үүнд :

1. Уул уурхайн хяналтын чиглэлийг МХЕГ-ын даргын баталсан 2.6 кодтой "Ил уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас", 2.7 кодтой "Далд уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас" -аар, 2.9 кодтой "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, худалдах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-аар,
2. Байгаль орчны хяналтын чиглэлийг 2.12 кодтой "Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн болон аж ахуйн нэгж байгууллагыг шалгах хяналтын хуудас"-аар,
3. Барилгын техникийн хяналтын чиглэлийг 5.3 кодтой "Барилгын материалын үйлдвэрийг шалгах хяналтын хуудас"-аар,

005050004663

4. 5.19.10 кодтой "Өргөх механизм ашигладаг аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг шалгах хяналтын хуудас" -аар,

5. Хэмжилзүйн хяналтын чиглэлээр 5.28.1 кодтой "Хэмжүүр хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг шалгах хяналтын хуудас"-аар,

6. Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр 4.1.1 кодтой "Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас", 4.1.2 кодтой "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас", 4.6 кодтой "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар,

7. Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр 4.2 кодтой "Ажилтаны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас"-аар шалгах

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, объектын нэр
Хяналт шалгалтад Мэргэжлийн хяналтын Ерөнхий газраас 2017 онд хяналт шалгалтад хамруулахаар зарлагдсан дараах аж ахуйн нэгжүүд хамрагдана. Үүнд:

Нийслэлийн Багануур дүүрэг дэх MV-13630, MV-01371, MV-13631 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч "Багануур" ХК.

Налайх дүүргийн дэвсгэрт байрлах нүүрс олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс:
MV-004561, MV-011853 тусгай зөвшөөрөл эзэмшигч "Таваншүтээн трейд" ХХК, MV-002645 тусгай зөвшөөрөл эзэмшигч "Ордтрейд" ХХК, MV-000183 тусгай зөвшөөрөл эзэмшигч "Налайх-Од" ХХК, MV-000876 тусгай зөвшөөрөл эзэмшигч "Зоогийн-Эх" ХХК, MV-015595 тусгай зөвшөөрөл эзэмшигч "Их-Урсгал" ХХК, MV-011125 тусгай зөвшөөрөл эзэмшигч "Сатурн прогресс" ХХК зэрэг 7 аж ахуйн нэгж хамрагдана.

Дөрөв. Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч

Хяналт шалгалтыг байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Т.Амарсайхан ахалж,

- Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Хэмжилзүйн хяналтын улсын байцаагч Д.Жаргалсайхан, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч П.Дашдаваа,

- Багануур дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Э.Өлзийбүрэн, барилгын техникийн хяналтын улсын байцаагч Н.Батзаяа, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Буяндэлгэр,

- Налайх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч Р.Лхагвасүрэн, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Ж.Алтанбагана, байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Ариунболд, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч А.Оюунтүлхүүр нар хамтран хийж гүйцэтгэнэ.

Шалгалтын явцад Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Өлзий байнгын хяналт тавьж ажиллана.

Тав. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ний өдрийн дотор хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл

Багануур дүүрэгт байрлах MV-13630, MV-01371, MV-13631 дугаартай тусгай зөвшөөрөл

эзэмшигч "Багануур" ХК-ийн үйл ажиллагаанд нь 2016 онд 4.1.1 код бүхий "Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас"-аар хяналт хийж үнэлэхэд эрсдэлийн үнэлгээ хамаарал бүхий 20.7 хувь буюу Бага, 4.1.2 код бүхий "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар хяналт хийж үнэлэхэд эрсдэлийн үнэлгээ 42 хувь буюу Дунд, 4.6 код бүхий "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар хяналт хийж үнэлэхэд 6.7 хувь буюу Бага, 5.2 код бүхий "Барилга байгууламжийн ашиглалтыг шалгах хяналтын хуудас"-аар хяналт хийж үнэлэхэд 42.7 хувь буюу Дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна.

Налайх дүүрэг дэх нүүрс олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд НМХГ-ын даргын 02-02/929 дугаартай удирдамж, Налайх дүүргийн Засаг даргын 2014 оны А\47, А\385 тоот захирамж, Налайх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга, дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн дарга нарын хамтран баталсан хяналт шалгалт хийх удирдамжуудын хүрээнд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.

Налайх дүүргийн нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Орд трейд", "Таван шүтээн трейд", "Эрдэнийн хөгжил", "Зоогийн-Эх", "Жиншинтан", "Налайх-Од" ХХК-ийн үйл ажиллагааг 4.1.1 код бүхий "Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас", 4.1.2 код бүхий "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас", 4.6 код бүхий "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас", 2.7 код бүхий "Далд уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас" үйл ажиллагааг нь шалгахад дээрхи аж ахуйн нэгжүүд бүгд их эрсдэлтэй байсан тул улсын байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлж, биелэлтэнд хяналт тавьж ажиллав.

Долоо. Шалгалтаар хийж гүйцэтгэх ажлууд

Төлөвлөгөөт шалгалтаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

Геологи, уул уурхайн хяналт:

- Уул уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орсон газрын нөхөн сэргээсэн талбайн судалгаа гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх,

- Уурхайн эдэлбэр газрын булангийн шав тэмдгийн тооллого хийх,

- Багануур дүүрэг дэх MV-13630, MV-01371, MV-13631 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч "Багануур" ХК-д эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах,

Байгаль орчны хяналт:

- Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн агаар хамгаалах арга хэмжээний талаар авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл,

- "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 101 дүгээр зүйлийн 1 дэх, 31 дүгээр зүйлийн 3, 4 дэх заалтад заасан шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт тавих,

- "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.7, 9.9 дэх, 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтуудын хэрэгжилтэд хяналт тавих,

- "Хог хаягдлын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтын хэрэгжилтэд хяналт тавих,

- "Агаарын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын хэрэгжилт болон агаар хамгаалах арга хэмжээний талаар авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл,

Хэмжилзүйн хяналтын чиглэлээр:

- Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бүх төрлийн хэмжих хэрэгслийн загварын туршилт, суурилуулалт, баталгаажуулалт, ашиглалтын байдлыг газар дээр нь шалгаж, судалгаа гаргах

Хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр:

- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гаргах,
- Ажлын байрны орчны эрүүл ахуйн нөхцөл, ажлын байранд тавигдах стандарт шаардлагын талаар судалгаа гаргах,

- Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр байгууллагын сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Долоо. Шалгалтын үр дүн, авах арга хэмжээ

Шалгалтын үр дүн, хяналтын чиглэл бүрээр хийгдсэн ажил, авсан арга хэмжээ, шинжилгээ, дүгнэлтийн талаарх танилцуулгыг 2017 оны 03 дугаар сарын 15-ний өдрөөс 03 дугаар сарын 20-ны өдрийн хооронд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлийг Налайх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч А.Оюунтүлхүүр,

- Байгаль орчны хяналтын чиглэлийг Багануур дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Э.Өлзийбүрэн,

- Налайх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Ж.Алтанбагана,

- Барилгын техникийн хяналтын чиглэлийг ДБХХ-ийн Хэмжилзүйн хяналтын улсын байцаагч Д.Жаргалсайхан нар нэгтгэн Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Т.Амарсайханд ирүүлэн нэгтгэгдэж, шалгалтын үр дүнг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын журамд заасны дагуу ажлын 21 хоногт багтаан хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

Шалгалтын мэдээллийг МХЕГ-ын 2010 оны 107 тоот тушаалын "Олон нийтэд мэдээлэл түгээх журам"-д заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ, УУЛ
УУРХАЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.БАТ ӨЛЗИЙ

ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  Н.ГАНТУЛГА

ТӨЛӨВЛӨСӨН:
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  Т.АМАРСАЙХАН

БАЙЦААГЧ
12-05-150